



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Халамжийн сан /Орон нутгийн төсөв/-гийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг:

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
.....	
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРСАНАА ТАНАА

2020.08.06 № 1/51

танай _____ -ны № _____ -т

г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/ -ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/ -ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/ -ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020012

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Халамжийн сан /ОНТ/-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сан /ОНТ/-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халамжийн сан /ОНТ/-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.28-наас 2020.02.03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /ОНТ/ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.02.03-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Халамжийн сан /ОНТ/-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэхэд халамж, асрамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог ханган хамтран ажиллах, хуваарилагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зөв зарцуулах, анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг арга зүйн удирдлагаар хангах ажилд манлайлагч байхад оршино” гэж тодорхойлсон

Халамжийн сан /ОНТ/ ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн сангийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг бодитой, үнэн зөв боловсруулах, холбогдох газруудад хүргүүлэн батлуулах.
- Батлагдсан төсвийн зарцуулалтыг улирал, хагас бүтэн жилээр иргэдэд болон хэлтсийн удирдлага хамт олонд нээлттэй тайлагнаж ажиллах
- Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах чиглэлээр санал санаачилга гарган, анхан шатанд ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
- Нийгмийн халамжийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах, бодитой, үнэн зөв хуваарилах, гэрээт банк уруу шилжүүлэх ажлыг чанартай зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Халамжийн сан /ОНТ/- ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Халамжийн сан /ОНТ/ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ““Финанс” программ хангамж ашигладаг байна.

Халамжийн сан /ОНТ/- ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Халамжийн сан /ОНТ/-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Халамжийн сан /ОНТ/-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 151185,0 мянган төгрөгөөс тооцон 3,036.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3036,3 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халамжийн сан /ОНТ/-гийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 0, өмнөх онд 95065,7 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн өглөгтэй гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	0	0	0
Нийт хөрөнгө	0	0	0
Өр төлбөр	95065,7	0	-95065,7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-95065,7	0	95065,7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0	0	0

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн /буурсан/ нь 2018 онд үүссэн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өглөгийг барагдуулсантай холбоотой..

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 151452,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 151185,0 мянган төгрөгийг халамжийн үйлчилгээнд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 151452,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд халамжийн тэтгэмж хөтөлбөрийн санхүүжилт 151185,0 мянга, өмнөх оны халамжийн тэтгэмжийн өр төлөхөд тодотголоор 94655,7 мянга, харилцах дансны хүүгийн орлого 360,3 мянган төгрөг, хяналт шалгалтын актын төлбөр 412,5 мянга нийт 246880,0 мянган төгрөгийн санхүүжилт авчээ.

Үүнээс амьжиргааны нөхцөлт мөнгөн тэтгэмжид 85,200.0 мянга, олон нийтийн оролцоот халамжийн үйлчилгээнд 65,985.0 мянга, нийт 151185,0 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх

оны өглөг 94665,7 мянган төгрөгийн халамжийн тэтгэмжийг олгож үлдэгдэл 1039,8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 109 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	9	9	7		2
2	Хагас жил	2	2	2		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	1	12	12		
	Тухай бүр	7	84	80	4	
	Нийт	20	111	109	4	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халамжийн сан/ОНТ/-гийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Халамжийн сан/ОНТ/-гийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	95,065,730.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	95,065,730.00	-
413	Өглөг	95,065,730.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	95,065,730.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(95,065,730.00)	-
51	Засгийн газрын хувь оролцоо	(95,065,730.00)	-
512	Хуримтлагдсан үр дүн	(95,065,730.00)	-
51210	Өмнөх үеийн үр дүн	(8,997,224.18)	(95,065,730.00)
51220	Тайлант үеийн үр дүн	(86,068,505.82)	95,065,730.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	-

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,060,169,182.79	246,880,576.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,292,982.79	772,846.16
120	Нийтлэг татварын бус орлого	20,292,982.79	772,846.16
120002	Хүүгийн орлого	2,487,330.14	360,346.16
120009	Бусад орлого	17,805,652.65	412,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,039,876,200.00	246,107,730.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,039,876,200.00	246,107,730.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	8,039,876,200.00	246,107,730.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,155,234,912.79	151,814,846.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,155,234,912.79	151,814,846.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,153,766,919.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,153,766,919.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,895,550.00	-
210813	Бусад зардал /ТӨҮГ/	8,147,871,369.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,467,993.79	151,814,846.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	150,775,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		150,775,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,467,993.79	1,039,846.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,467,993.79	1,039,846.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(95,065,730.00)</u>	<u>95,065,730.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(95,065,730.00)</u>	<u>95,065,730.00</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,085,764,650.79	246,880,576.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,888,450.79	772,846.16
120	Нийтлэг татварын бус орлого	45,888,450.79	772,846.16
120002	Хүүгийн орлого	2,487,330.14	360,346.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,595,468.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,595,468.00	-
120009	Бусад орлого	17,805,652.65	412,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,039,876,200.00	246,107,730.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,039,876,200.00	246,107,730.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,039,876,200.00	246,107,730.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,085,764,650.79	246,880,576.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,085,764,650.79	246,880,576.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,895,550.00	94,655,730.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,895,550.00	94,655,730.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,895,550.00	
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	94,655,730.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,079,869,100.79	152,224,846.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,078,401,107.00	151,185,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,078,401,107.00	151,185,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,467,993.79	1,039,846.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,467,993.79	1,039,846.16
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	-95,065,730.00	0.00	-95,065,730.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-95,065,730.00	0.00	-95,065,730.00
Тайлант үеийн үр дүн		95,065,730.00		95,065,730.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
УРСГАЛ ЗАРДАЛ	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
Бусад урсгал шилжүүлэг	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%
Орон нутгийн төсвөөс	151,452,000.00	151,185,000.00	267,000.00	99.8%

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.06

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО 2020.02.06

ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО 2020.02.03